АЖЛЫН ДААЛГАВАР

Төсөл, арга хэмжээний нэр: **“Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын пост нийлүүлэх”**

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Төслийн зорилго	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Германы Сэргээн босголт, Зээлийн банк *(KfW)*-аар дамжуулан Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ)-ны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн II, III үе шатны үйл ажиллагаа 2020 оны 3 дугаар сараас эхлэн хэрэгжиж байна. Төслийн зорилго: Монгол орны Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн сүлжээнд (Орчны бүс нутаг болон Орон нутгийн захиргаад, иргэд) чухал ач холбогдол бүхий газруудын үр ашигт байдал, тогтвортой менежментийг сайжруулах, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааны шинэ эх үүсвэрүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх юм.
2.	Ажлын үндэслэл, зорилго	Монгол Улсын хэмжээнд ТХГН-т байгаль орчны хууль тогтоомж хэрэгжүүлэх эргүүл, хяналт шалгалт, мониторинг хийх нөхцөлийг сайжруулах, байгаль хамгаалагчид, судлаачид онцлог нөхцөл, халуун цэгүүдэд хяналт, мониторингийн ажиллагаа явуулахад Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын пост чухал шаардлагатай. Хамгаалалтын захиргаадын хэрэгцээ шаардлагад үндэслэн ТХГН-ийн 18 хамгаалалтын захиргаанд “Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын пост нийлүүлэх” бараа худалдан авах ажлыг төслийн 2025 оны үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган баталсан нь энэхүү худалдан авах ажиллагааны үндэслэл болно. Сонгосон ТХГН-ийн 18 хамгаалалтын захиргаанд Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын постыг туршилтаар нийлүүлж, ашиглалтын үр дүнг үнэлэх зорилготой юм. Энэхүү тендерээр худалдан авах “Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын пост” гэж тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын олон улсын стандартад нийцсэн, үйлдвэрийн баталгаа бүхий явах эд анги дээр суурилуулсан 4 хүний багтаамжтай чиргүүлийн сууцыг ойлгоно.

3.	Хамрах хүрээ	Тус тендерийн хүрээнд төсөлд хамрагдаж байгаа дараах 18 хамгаалалтын захиргаанд Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын пост тус бүр 1 ширхгийг нийлүүлэн хүлээлгэж өгнө. Үүнд: 1. Монгол-Алтайн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаа 2. Ачит нуур- Дэвэлийн арлын БЦГ-ын хамгаалалтын захиргаа 3. Говийн их ДЦГ-ын “А” хэсгийн хамгаалалтын захиргаа 4. Говийн их ДЦГ-ын “Б” хэсгийн хамгаалалтын захиргаа 5. Говийн бага ДЦГ-н хамгаалалтын захиргаа 6. Говь Гурвансайханы БЦГ-н хамгаалалтын захиргаа 7. Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргаа 8. Их богдын БЦГ-ын хамгаалалтын захиргаа 9. Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа 10. Монгол элсний БЦГ-ын хамгаалалтын захиргаа 11. Мөнххайрханы БЦГ-ын хамгаалалтын захиргаа 12. Мянган угалзатын БЦГ-ын хамгаалалтын захиргаа 13. Нөмрөгийн ДЦГ-ын хамгаалалтын захиргаа 14. Увс нуурын ай савын УТХГ- ын хамгаалалтын захиргаа 15. Хар-Ус нуур орчмын УТХГ-ын хамгаалалтын захиргаа 16. Хан хөхийн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаа 17. Хомын талын БЦГ-н хамгаалалтын захиргаа 18. Хөх сэрхийн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаа
4.	Хүлээн авах бараа, тоо ширхэг	Тус тендерийн хүрээнд тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд ашиглагдаж байгаа TOYOTA Лэнд Круйзер-76, 79 болон Nissan Y-61 маркийн суудлын автомашинаар чирэх зориулалтын Ажлын даалгаврын нэгдүгээр хавсралтад заасан техникийн тодорхойлолт, тоо ширхэг, дагалдах бараа материал, тоноглол, хоёрдугаар хавсралт дахь схемээр үзүүлсэн овор хэмжээ, гадаад дотоод хийцийн ерөнхий дизайн бүхий Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын пост 18 ширхэг барааг Захиалагчид хүлээлгэн өгнө.
5.	Хийх ажлын иж бүрдэл	Гэрээнд болон хавсралтад заасан тоо, чанар, техникийн тодорхойлолт, хийц дизайн, иж бүрдэл бүхий 18 ш Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын постыг дараах шаардлагын дагуу нийлүүлэхдээ дараах асуудлуудыг хариуцна. Үүнд: 5.1 Ажлын даалгаврын нэгдүгээр хавсралтад заасан үзүүлэлт бүхий олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн суудлын авто машины чиргүүлийн стандарт шаардлагын дагуу үйлдвэрлэгдсэн явах анги, хоёрдугаар хавсралтад

		үзүүлсэн ерөнхий дизайн схемд нийцэх сууцны хэсэг бүхий Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын постыг нийлүүлэх, 5.2 Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын постыг захиалагчид Улаанбаатар хотод хүлээлгэн өгөх бөгөөд ТХГН-ийн хамгаалалтын захиргаад тус хөдөлгөөнт хяналтын постыг чирэх автомашинтайгаа ирж хүлээн авна. Энэ үед хөдөлгөөнт хяналтын постыг чирэх авто машины порхов (хойд чирэх дэгээ)-г чиргүүлийн савлагаа машинд үл нөлөөлөх, эргэдэг бултай порховоор сольж Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын постыг холбон чирч явах боломжтойгоор суурилуулж өгөх, 5.3 Мөн ашиглалт, засвар үйлчилгээ, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай мэдээлэл агуулсан сургалтыг хамгаалалтын захиргааны холбогдох хүмүүст зориулан зохион байгуулж, гарын авлагыг Монгол хэл дээр бэлтгэж, бараа бүтээгдэхүүний хамт хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгнө.
6	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 150 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ. **Гэрээний нийт үргэлжлэх 150 хоногийн хугацаа нь Гэрээлэгч барааг Захиалагчид хүлээлгэн өгч, акт үйлдэж, Захиалагч гэрээний эцсийн төлбөрийг Гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн байхаар тооцсон хугацаа болно.*
7	Хүрэх үр дүн	7.1 ТХГН-ийн хамгаалалтын захиргааны онцгой цэгүүдэд хийх гэнэтийн хяналт шалгалт, мониторингийн ажлын үр дүн, байгаль хамгаалагч, ажилтнуудын ажлын бүтээмж, ажиллах нөхцөл боломжууд сайжирна. 7.2 Төсөлд хамрагдсан ТХГН-ийн мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын байгаль орчны хээрийн эргүүл хяналт мониторингийн ажлын үр дүнг ахисан шатанд хийх, цаг хугацаа, шатахуун, хүн хүч хэмнэх боломж бүрдэж мэдээ баримт цуглуулах, онцлог халуун цэгүүдэд системтэй урт хугацаанд хяналт хийх чадавх сайжирна. 7.3 Байгаль орчин, биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах ажилд ахиц гарч, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
8	Тендерт оролцогчид тавигдах шаардлага	8.1 Тендерт оролцогчид дараах ерөнхий шаардлага тавигдана. Үүнд: - Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлагыг хангасан байх,

		- Захиалагчаар батлагдсан ажлын даалгаврын заалт, техникийн үзүүлэлт, зураг схемийн шаардлага хангах, - Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага, MNS 4598-2003, - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн заалт шаардлагууд, - Стандартчилал, техникийн зохицуулалтын тухай хуулийн холбогдох заалт шаардлагууд болон журам, дүрэм, шаардлагуудыг хангаж ажиллах, - Тендерийн баримт бичигт заасан Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголт, Зээлийн банк (*KfW*)-ны бусад нөхцөл, шаардлага, - БОЯБХУАӨДЗТ-ийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог баримтална (https://baccp.mn/project/detail_3. 8.2 Тендерт оролцогчдод дараах шаардлага тавигдана. Үүнд: 8.2.1 Сүүлийн 2 жилийн хугацаанд 2023, 2024 онуудад тендерийн төсөвт өртгийн **50 хувиас** багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласныг нотлох. Үүнд: - Гүйцэтгэсэн 2-оос доошгүй ажлын гэрээ, гэрээний биелэлт дүгнэсэн акт ирүүлэх, 8.2.2 Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын посттой ижил төрлийн хэрэгсэл үйлдвэрлэдэг гадаад улсын үйлдвэрийн борлуулалт хийх эрх (патент)-ийг үйлдвэрлэлд ашиглах эрх, гэрээ, зөвшөөрлийн баталгааг ирүүлэх, 8.2.3 Чанарын баталгаат хугацаанд гарч болзошгүй эвдрэл гэмтлийг засварлах болон ашиглалтын явцад засвар үйлчилгээ үзүүлэх боломжтой байх, 8.2.4 Ижил төстэй бараа бүтээгдэхүүний загварыг биет байдлаар үзүүлэх,
7	Захиалагч байгууллага	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
8	Санхүүжилтийн эх үүсвэр	Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Германы Сэргээн босголт, Зээлийн банк (*KfW*)-аар дамжуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III” BMZ 201667054, 201868272 төсөл

9	Нийт санхүүжилт	1,024,160,760 (Нэг тэрбум хорин дөрвөн сая нэг зуун жаран мянга долоон зуун жаран) төгрөг.
10	Худалдан авах ажиллагаанд дагаж мөрдөх хууль, дүрэм журам	- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголт, зээлийн банк (*KfW*)-ны "Түншлэгч улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, барааны болон зөвлөх бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны удирдамж"; - Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголт, Зээлийн банк (*KfW*)-ны Байгаль Орчин Нийгмийн Менежментийн шаардлага, стандартууд; - Санхүүжүүлэгчээр батлагдсан Бараа нийлүүлэх тендерийн баримт бичиг; - Захиалагчаар батлагдсан Тендерийн баримт бичиг болон Ажлын даалгавар;

"Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын пост нийлүүлэх" тендерээр худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг нэгдүгээр хавсралтаар, овор хэмжээ, гадаад дотоод хийцийн ерөнхий дизайн схемийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлав.

---------- 0 ---------- 0 ---------- 0 ----------

АЖЛЫН ДААЛГАВРЫН НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын постын эд анги, тоног хэрэгслийн техникийн тодорхойлолт

Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын пост			
Шаардлагатай тоо		18 ширхэг	
Зориулалт		Явуулын эргүүл, хяналт, шалгалт, мониторингийн үед TOYOTA Лэнд Круйзер-76, 79 болон Nissan Y-61 маркийн суудлын автомашинаар чирч онцгой газруудад байрлуулан байгаль хамгаалагч судлаачид хоноглох, амрах, дулаацах,	
Өнгө		Байгаль, зэрлэг амьтанд сөрөг нөлөөгүй байгалийн өнгөтэй байх	
НЭГ: ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ			
д	**Эд анги**	**Техникийн үзүүлэлт**	**Шаардлага**
Явах ангийн үзүүлэлт			
1	Суурь рам	Зэвэрдэггүй ган (-50^{0}С хүртэл хүйтэнд тэсвэртэй)	Явах эд анги нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, суудлын автомашины чиргүүлийн стандартын дагуу үйлдвэрлэгдэж туршигдсан “Black series” аяллын чиргүүлийн чанар стандарт буюу түүнтэй дүйцэхүйц байх. Бүтнээр нь импортлох тохиолдолд үйлдвэрлэгчийн албан ёсны гэрээт борлуулагч болохыг нотолсон гэрээ эсхүл бусад нотлох баримтыг ирүүлнэ.
2	Тэнхлэг	Үл хамаарах	
3	Суурилуулах тулгуур	Хоноглох буюу зогсоолын үед ашиглах тулгуур нь: Механик ажиллагаатай, газрын хэвгийн нөхцөлд тохируулан байрлуулахад тохиромжтой 4 тулгуур хөлтэй байх.	
4	Амортизатор	4 ш (80мм)	
5	Пүрш	2 ш (φ20*φ140*325)	
6	Урд машинаас чирэгч	Порхов буюу чирэх бул нь машин ба чиргүүл хооронд үл хамаарах, эргэдэг бултай, бартаат зам, хүнд нөхцөлд ашиглахуйц байх	
7	Тоормос	Гар тоормос	
8	Шат	Механик эвхэгддэг төмөр шат	
9	Дугуйн хэмээ	Үндсэн 2 ш + запаас 1 ш (265/75/R16)	
10	Дугуйн обуд	Ган/хайлш	
11	Холболтын өндөр	50 см -ээс багагүй,	
Овор хэмжээний үзүүлэлт			
1	Оврын хэмжээ Урт/Өргөн/Өндөр (мм)	4900-аас багагүй /2000-аас багагүй/2800-аас багагүй	Авто замын хөдөлгөөний тухай хууль тогтоомж болон суудлын машины
2	Шалны талбай	7.5 м2 -аас багагүй	

3	Бүх жин (кг)	1500-аас ихгүй байх ба энгийн SUV (туулах чадвар сайтай) ангиллын машинаар чирэх боломжтой	чиргүүлийн овор хэмжээнд тавьдаг шаардлага хангасан байх
4	Орны тоо	4-өөс цөөнгүй /эвхэгддэг ор 2 ш, агуулахтай ор 2 ш/	
5	Газраас тэнхлэг хүртэлх зай (мм)	200 мм-ээс багагүй	
Гадна бүхээгийн үзүүлэлт			
1	Гадна бүрээс, хана, дээврийн хийц	Зэвэрдэггүй ган каркас, хөнгөн цагаан нийлмэл хавтан, ган хавтан дээр шүршмэл будагтай, зэвэрдэггүй ган бариултай, Төмөр хөндлөн болон босоо бүслүүртэй, Ханын зузаан: 5см болон түүнээс дээш зузаантай байх	Нар, салхи болон агаарын температурын өөрчлөлтийн нөлөөнд тэсвэртэй материал, өнгө будагтай байх
2	Дотоод заслын хийц	Хана, тааз нь дундаа дулаан тусгаарлагч 2.5-5.0 см зузаантай чулуун хөвөн, Хана: UV бүрэлттэй хавтангаар хийсэн байна, Тааз: Хулсан хавтан таазтай,	Хүний эрүүл мэндэд харш өнгө, үнэргүй, галд тэсвэртэй материалаар хийгдсэн байх
3	Цонх	Дулаан тусгаарлагчтай, хөнгөн цагаан материалтай, 2 давхар вакуум цонх. 4-өөс доошгүй цонхтой байх	Вакум цонхны стандартад нийцсэн байх
4	Хаалга	Дулаан тусгаарлагч бүхий төмөр	кодоор түгжигдэж онгойдог цоожтой байх
5	Шал	Ус чийг, температурын нөлөөлөлд тэсвэртэй, хатуу гадаргуутай SPC хулдаас	Халтирч гулгахааргүй, цэвэрлэхэд хялбар материал
6	Хойд гэрэл ойлгогч/цацруулагч	Стандартын дагуу	Харанхуй бүрэнхий болон манантай үед 10 метрээс багагүй зайнаас тод харагдахуйц
Аюулгүй байдлын үзүүлэлт			
1	Галын хор	CE болон ISO стандартын ABC нунтаг галын хор.	Хадгалах хугацаа: 2-оос доошгүй жил
2	Ослын гурвалжин	2 ширхэг	Эвхдэг
3	Эмийн сан	Ком хэрэгсэл	MNS 4979:2016 стандартын дагуу
4	Халаалтын зуух, яндангийн галын аюулгүй байдал	Зуухны эргэн тойрны хана, яндангийн гаралтын хэсгийг гал дулаан үл дамжуулах материалаар галын тусгаарлалт хамгаалалт хийсэн байх	Гал болон дулаан тусгаарлагчид асбесто болон түүнтэй төстэй материал хэрэглэхийг хориглоно

5	Гадна, дотор хана, тааз, шална материал	Гадна, дотор хана, тааз, шалыг галд тэсвэртэй, гал дэмждэггүй материалаар хийнэ	Галд шатамхай материал хэрэглэхийг хориглоно
Дотор тавилга, хэрэгсэл			
1	Халаагуур	1 иж бүрдэл, Ердийн зуух (зуухны хана нь 2мм-ээс багагүй зузаантай, ган төмрөөр эсвэл ширмээр хийгдэх) овор хэмжээ нь дотоод орон зайд зөв зохицсон байх	Аргал, хоргол, нүүрс түлэх боломжтой байх 4 хүний тогоо тавьж хоол цай хийх боломжтой байх
2	Ханын шүүгээ	1 иж бүрдэл	Ус чийгт тэсвэртэй, хээрийн нөхцөлд олон удаа ашиглах нөхцөлийг хангах материалаар хийгдсэн байх, Зөөврийн хийн зуух тавьж ашиглах боломжтой байх
3	Гал тогооны хэсэг	1 иж бүрдэл, Чулуун хавтан бүхий тавцантай зориулалтын шкаф шүүгээтэй, бартаат замын хөдөлгөөний үед бат бэх шаардлага хангах	
4	Хөргөгч	1 иж бүрдэл, 70 литр	Нарны зайн эх үүсвэрээр 12Вт-оор ажиллах боломжтой байх
5	Ор	Бүгд 4 ш, эвхдэг дээд давхрын ор 2 ш, доод давхрын тусдаа ор 2 ш	Доод орны доорх зайг ашиглах боломжтой тохижуулах
6	Орны матрас	4 ширхэг, орны урт өргөний хэмжээтэй, 8-15 см зузаантай мемори хөөсөн зөөлөвч,	Орны матрасыг угааж цэвэрлэхэд хялбар, даавуун бүрээстэй, ортой бэхэлсэн байх,
7	Аккумлятор	1 ширхэг Хүчдэл: 12В Нэгж багтаамж: 400А/ц Төрөл: Lead Carbon төрлийн хүйтэнд тэсвэртэй Ажиллах температур: -40^{0}С-50^{0}С Циклийн тоо (багадаа): 3000 Цэнэг алдалт (сараар): 3%	Стандартын гэрчилгээтэй байх
8	Цахилгаан	1 ширхэг нарны дэлгэц хавтан 400 ватт-аас дээш чадалтай	Нарны цахилгаан дэлгэц нь моно-кристал байх бөгөөд 400-580Вт чадалтай байх

9	Нарны зайн хяналтын самбар	1 иж бүрдэл	Дээрх тодорхойлолт бүхий дэлгэц, аккумляторт цахилгаан хүчдэл хуваарилах, хянах зориулалтаар зориулан үйлдвэрлэсэн.
10	Гэрэлтүүлэг	1 ш -ээс цөөнгүй, эрчим хүчний хэмнэлттэй LED гэрэл	Унтлагын болон гал тогооны хэсэг тус бүрийг хангалттай хэмжээнд гэрэлтүүлэх боломжтой байх
11	Унтраалга	1 ш -ээс цөөнгүй	
12	Цахилгааны шит самбар	1 ш, цахилгааны эх үүсвэрээс оруулга, хэрэглэгчид хуваарилах гаргалгааны холбогч салгагчтай, 2ш-ээс цөөнгүй гал хамгаалагч суурилуулах боломжтой байх	цахилгааныг хэрэглээний зориулалт тус бүрд болон нэмэлт хэрэглээнд хуваарилах холболт хийх боломжтой байх
13	12V-ын цахилгааны залгуур	2 ш -ээс багагүй, 19.5В хүчдэлээр ажиллах компьютер болон 5В хүчдэлээр гар утас цэнэглэх боломжтой байх	Дотор хажуу хана тус бүрд, хүн хүрэхэд хялбар зайд байрласан байх
14	Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын хугацаа	1-ээс багагүй жил	Албан бичгээр баталгаа гаргаж ирүүлэх
15	Гарын авлага	Монгол хэлээр	

---------- 0 ---------- 0 ---------- 0 ----------

АЖЛЫН ДААЛГАВРЫН ХОЁРДУГААР ХАВСРАЛТ

Байгаль хамгаалагчийн хөдөлгөөнт хяналтын постын овор хэмжээ, гадна, дотор хийцийн ерөнхий дизайн схем

Схем 1. Байгуулалт



Схем 2. Огтлол



Схем 3. Хажуугаас харагдах байдал



---------- 0 ---------- 0 ---------- 0 ----------